

Монгол Улсын баялгийн сангуудын эдийн засаг дахь нөлөө

Ц.Оюунзул

Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн

Б.Нямбаатар

Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн

Судалгааны зорилго

“Монгол улсын баялгийн сангуудын эдийн засаг дахь урт хугацааны нөлөөг үнэлэх”

- 1. Төсвийн тогтворжуулалтын сан (2011)** – Төсвийн зарлагын дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах замаар ашигт малтмалын үнийн хэлбэлзлээс эдийн засагт үүсэх хэлбэлзлийг бууруулах зорилготой
- 2. Ирээдүйн өв сан (2017)** – Уул уурхайн салбараас орох орлогыг өнөөгийн болон ирээдүйн үеийнхэнд хуваарилах

Судлагдсан байдал

- Рагчаасүрэн (2014):
 - CGE загвар ашиглан ТТБТХ-ийн эдийн засаг дахь нөлөөг үнэлсэн
 - Үр дүн: ТТБТХ нь ашигт малтмалын үнээс үүдэх эдийн засгийн үзүүлэлтүүдийн хэлбэлзлийг бууруулах нөлөөтэйг тогтоосон
- Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн (2017, 2019):
 - ТТБТХ-ийн тусгай шаардлагуудын эдийн засгийн нөлөөг CGE Загвар ашиглан үнэлсэн
 - Үр дүн: Ашигт малтмалын үнийн хэлбэлзлийн төсөвт үзүүлэх нөлөөг бууруулах, эдийн засгийн уул уурхайн салбараас хараат байдлыг бууруулах
 - Төсвийн зардлын хязгаарын тусгай шаардлага нь эдийн засгийн хэлбэлзлийг бууруулахад хамгийн чухал нөлөөтэй
- Рагчаасүрэн ба бусад (2017, 2018):
 - Монгол улсын төсвийн тогтвортой байдлыг Монголын Макро-Төсвийн Загвар ашиглан шинжилсэн
- Баялгийн сангуудын эдийн засаг дахь нөлөөг үнэлсэн судалгаа хийгдээгүй

Судалгааны арга зүй

Тооцоологдох ерөнхий тэнцвэрийн загвар

- Бодлогын болон шокийн шинжилгээний арга
- Үйлдвэрлэлийн олон салбар
- Эдийн засгийн агентууд
- Бүтээгдэхүүн, хүчин зүйл, санхүүгийн зах зээлүүд
- Давуу тал:
 - Эдийн засгийн ерөнхий дүр зураг
 - Салбаруудын уялдаа холбоо
 - Зах зээлийн хуваарилалтын механизм буюу өгөө аваа (trade-off)
 - Нөөцийн хязгаарлалт
 - Шууд ба шууд бус нөлөө

Монголын динамик ерөнхий тэнцвэрийн загвар

- “PEP-1-t” загварын өргөтгөсөн хэлбэр
 - ЗГ-ын өрийн динамик
 - Хөрөнгө оруулалтын задаргаа
 - Салбаруудын нийт хүчин зүйлийн бүтээмж (TFP)

Төсвийн тогтворжуулалтын сан

- **Орлогын эх үүсвэр:**

- Голлох ашигт малтмалын бодит үнэ тэнцвэржүүлсэн үнээс давсны улмаас үүсэх төсвийн нэмэлт орлого,
- ТТС-гийн санхүүгийн үйл ажиллагааны цэвэр орлого
- Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ашиг

$$\begin{aligned} Stock_{FSF,t} &= Stock_{FSF,t-1} * (1 + int_rate_t) + Net_change_{FSF,t} \\ Net_change_{FSF,t} &= YG_t - YG_Eq_t - Net_change_{FHF,t} \end{aligned}$$

- **Дараах тохиолдлуудад ТТС-аас улсын төсөв рүү шилжүүлэг хийнэ:**

- Голлох ашигт малтмалуудын үнэ буурснаас төсвийн орлого тасалдах
- Голлох ашигт малтмалуудын экспортын биет хэмжээ 20 буюу түүнээс өндөр хувиар буурснаас төсвийн орлого тасалдах
- Төсвийн алдагдал төсвийн төсөлд тусгаснаас ДНБ-ий 4 хувьтай тэнцэхүйц хэмжээгээр хэтрэх

(ТТБТХ 16.2.1, 16.2.4)

Ирээдүйн өв сан

- **Орлогын эх үүсвэр:**

- АМНАТ-ын орлогоос ТБТХ-ийн дагуу ТТС-д хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчит компаниудын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг
- 2030 оноос эхлэн сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогоос улсын төсөв рүү шилжүүлэг хийсний дараа санд үлдэх хэсэг

- **Зарлага:**

- 2030 он хүртэл сангийн хөрөнгөөс зарцуулалт хийхгүй
- 2030 оноос хойш сангийн цэвэр орлогын 10 хувийг улсын төсөв рүү шилжүүлнэ
- Ирээдүйн өв сан корпорацын удирдлагын зардал

$$Net_change_{FHF,t}$$

$$= 0.65 * 0.05 * Sum[mc, EXD_{mc,t} * PEfob_{mc,t} + Q_{mc,t} * PC_{mc,t}] + YGK_t$$

(ИӨСТХ 7.1.1, 7.1.2)

$$Stock_{FHF,t} = Stock_{FHF,t-1} * (1 + int_rate_t) + Net_change_{FHF,t}$$

(2030 он хүртэл)

$$Stock_{FHF,t} = Stock_{FHF,t-1} * (1 + 0.9 * int_rate_t) + Net_change_{FHF,t}$$

$$YG_t = YGK_t + Taxes_t + Transfers_t + Stock_{FHF,t-1} * (1 + 0.1 * int_rate_t)$$

(2030 оноос хойш)

(ИӨСТХ 9.5, 9.6)

Баялгийн сангуудтай холбоотой загварын өргөтгөл, өөрчлөлтүүд

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого

$$YG_{Eq_t} = YG_t - Net_change_{FSF,t} - Net_change_{FHF,t}$$

(ТТБТХ 6.1.1)

Сангуудын хөрөнгийн удирдлага: Зөвхөн гадаад зах зээлд хөрөнгө оруулалт хийх

$$Total_investment_t = SH_t + SG_t + SROW_t - Net_change_{FSF,t} - Net_change_{FHF,t}$$

$$YROW_t = Imports_t + Transfers_t + Net_change_{FHF,t} + Net_change_{FSF,t}$$

(ТТБТХ 17.1, ИӨСТХ 12.1.5)


Тоон өгөгдөл

Монгол улсын 2017 оны Нийгмийн Тооцооллын Матриц (ДНБ-д эзлэх хувь)

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1 Хөдөлмөр								0.6	45.2						46
2 Капитал								0.1	45.4						45
3 Өрхүүд	44.8	33.6		11.6				2.1							92
4 ЗГ			3.2		13.1	1.7	7.4	0.2	0.4		0.0				26
5 Шууд татвар			13.1												13
6 Импортын тариф										1.7					2
7 ШБТ										7.4					7
8 Гадаад сектор	0.9	11.9	0.7	2.0						56.3					72
9 Салбарууд										126.2	53.8				180
10 Бүтээгдэхүүнүүд			53.5	12.7					89.1	15.2	4.9	18.7	5.9	6.7	207
11 Экспорт								58.7							59
12 Хувийн ХО			17.4	(0.3)				8.3							26
13 Төрийн ХО			4.0	(0.1)				1.9							6
14 Нөөцийн өөрчлөлт												6.7			7
15 НИЙТ	46	45	92	26	13	2	7	72	180	207	59	25	6	7	

ҮБС-уудын Монголын эдийн засагт үзүүлэх нөлөөний үнэлгээ


Шинжилгээний арга



Хувилбарууд


- Суурь хувилбар: ТТС ба ИӨС аль аль нь байхгүй
- Хувилбар 1: Зөвхөн ТТС байгаа
- Хувилбар 2: Зөвхөн ИӨС байгаа
- Хувилбар 3: ТТС ба ИӨС аль аль нь байгаа

Зэсийн үнэ, ам.доллар/тонн



— Тэнцвэржүүлсэн — Таамаглал


Нүүрсний үнэ, ам.доллар/тонн




— Тэнцвэржүүлсэн — Таамаглал

Үр дүн: Төсвийн тогтворжуулалтын сан

ТТС-гийн цэвэр өөрчлөлт, тэрбум төгрөг




ТТС-гийн хөрөнгө, тэрбум төгрөг




Үр дүн: Ирээдүйн өв сан

ИӨС-гийн цэвэр өөрчлөлт, тэрбум төгрөг




ИӨС-гийн хөрөнгө, их наяд төгрөг




Үр дүн: Баялгийн сангуудын ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого, их наяд төгрөг



Төсвийн нийт зардал, их наяд төгрөг



Үр дүн: Баялгийн сангуудын ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Хувилбаруудыг харьцуулах нь: Төсвийн үзүүлэлтүүд

	Дундаж өсөлт				Стандарт хазайлт			
	Суурь	ТТС-тай	ИӨС-тай	ТТС болон ИӨС-тай	Суурь	ТТС-тай	ИӨС-тай	ТТС болон ИӨС-тай
Төсвийн орлого	4.3	4.4	4.2	4.3	5.1	0.8	4.6	1.0
Төсвийн зардал	4.3	4.4	4.2	4.3	4.7	0.7	4.3	0.9
Хөрөнгийн зардал	4.8	4.2	4.8	3.3	20.3	6.4	27.8	13.5

Үр дүн: Баялгийн сангуудын макро эдийн засгийн хувьсагчдад үзүүлэх нөлөө

Макро хувьсагч	Дундаж өсөлт				Стандарт хазайлт			
	Суурь	ТТС-тай	ИӨС-тай	ТТС болон ИӨС-тай	Суурь	ТТС-тай	ИӨС-тай	ТТС болон ИӨС-тай
Бодит ДНБ	4.38	4.37	4.16	4.15	0.64	0.57	0.54	0.50
Уул уурхайн бус ДНБ	4.21	4.24	4.10	4.13	3.36	2.35	3.31	2.37
Өрхийн хэрэглээ	4.22	4.23	4.07	4.07	3.76	3.64	3.80	3.70
Засгийн газрын хэрэглээ	3.87	3.83	3.93	3.90	2.92	2.32	2.88	2.33
Нийт хөрөнгө оруулалт	3.77	3.77	3.59	3.58	7.18	3.58	7.04	3.61
Экспорт	4.41	4.41	4.34	4.35	6.87	7.20	6.99	7.29
Импорт	4.15	4.16	4.08	4.09	5.02	3.43	4.95	3.46
ХҮИ	-0.01	0.01	0.06	0.08	2.03	1.55	2.00	1.55

Дүгнэлт

- Төсвийн тогтворжуулалтын сан нь төсвийн зардлыг тогтворжуулах замаар эдийн засгийн хэлбэлзлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.
- Ирээдүйн өв сан нь засгийн газрын худалдан авалтыг бууруулах замаар эдийн засаг дахь нийт эрэлтийг бууруулах боловч уул уурхайн орлогыг өнөө болон ирээдүй үеийнхэнд хуваарилахад тусална.
- Монгол улсын Засгийн газар баялгийн сангуудын үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлж, ашигт малтмалын үнийн савлагаанаас үүдэлтэй эдийн засгийн мөчлөгийг сөрсөн бодлого тууштай баримтлах нь урт хугацааны тогтвортой өсөлтийг хадгалахад чухал үүрэгтэй юм.

Анхаарал тавьсанд баярлалаа